



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/130

Бат-Өлзий сум

Шууд гэрээ байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2,4 дүгээр багуудад худаг засварлах материал худалдан авах ажлыг 3 дугаар багийн иргэн В.Бямбасүрэнтэй шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгүүлсүгэй.
2. Иргэн В.Бямбасүрэнтэй гэрээ байгуулж, ашиглалтын явцад хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.
3. Зардалд шаардагдах 2,500,000 (хоёр сая таван зуун мянган) төгрөгийг гэрээний дагуу зарцуулахыг Санхүүгийн албаны нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.
4. Санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн авч төлбөр тооцоог хийж гүйцэтгэхийг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН